



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-25
<hr/>	
1. <i>Зөвлөлдөх санал асуулгын үр дүнгийн талаар мэдээлэл сонсох</i>	5-24
2. <i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	24-25

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 03 дугаар сарын 15-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 37 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Ганбаатар, Х.Нямбаатар;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Мөнхбат, Ц.Мөнх-Оргил.

Нэг.Зөвлөлдөх санал асуулгын үр дүнгийн талаар мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Үндэсний статистикийн хорооны дэд дарга Д.Лхамсүрэн, Үндэсний статистикийн хорооны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын дарга Ш.Ариунболд, Зөвлөлдөх зөвлөлийн дарга Г.Чулуунбаатар, Зөвлөлдөх зөвлөлийн гишүүн О.Мөнхсайхан, Зөвлөлдөх зөвлөлийн ажлын албаны дарга Н.Лувсанжав, ажлын албаны гишүүн Ц.Товуусүрэн, ажлын албаны гишүүн, Нийслэлийн бодлогын шинжилгээ, судалгааны төвийн Нийгэм, эдийн засгийн судалгааны газрын захирал А.Амарбал, ажлын албаны гишүүн, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Зөвлөлдөх зөвлөлийн ажлын албаны гишүүн Г.Золжаргал, О.Нарантуяа нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, Улсын Их Хурлын даргын зөвлөх О.Номинчимэг нар байлцав.

“Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний Зөвлөлдөх санал асуулгын үр дүнгийн талаарх мэдээллийг Зөвлөлдөх зөвлөлийн дарга Г.Чулуунбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Бямбацогт, Ц.Мөнхцэцэг, Н.Энхболд нарын тавьсан асуултад Зөвлөлдөх зөвлөлийн дарга Г.Чулуунбаатар, Зөвлөлдөх зөвлөлийн гишүүн О.Мөнхсайхан, Зөвлөлдөх зөвлөлийн ажлын албаны дарга Н.Лувсанжав, ажлын албаны гишүүн Ц.Товуусүрэн, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Н.Энхболд: “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 07 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 44 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.МӨНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордны “Жанжир Д.Сүхбаатар”
танхим
12 цаг 37 минут*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны ирц бүрдсэн учраас 2023 оны 03 сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдөр Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганы нэгдсэн хуралдаан эхэлсэн. Чуулганы нэгдсэн хуралдаан, чуулганы үйл ажиллагаа эхэлж байна. Бүгдээрэнгийнх нь ажилд амжилт хүсье.

Манай Байнгын хороо энэ хаврын чуулганы хугацаанд нийгмийн, улс төрийн, төрийн байгуулалттай холбоотой нэлээд олон чухал хуулиудыг хэлэлцэнэ.

Энэ манай хэлэлцэх асуудлын жагсаалтад ч орсон байгаа. Олон нийтийн зүгээс хүлээлт ч байгаа.

Мөн Зөвлөлдөх санал асуулгын дагуу Зөвлөлдөх зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдэд ч энэ хуулиудыг хэлэлцэх талаар.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр орсон зүйлүүдийн араас гарах бусад хуулиудыг бас бид энэ хаврын чуулганаар хэлэлцэх учраас их хариуцлагатай өндөр ачаалалтай чуулган болох байх болно.

Байнгын хорооны хувьд ялангуяа. Тийм учраас гишүүддээ идэвхтэй оролцохыг хүсье. Ажилд нь амжилт хүсьеж байна.

Өнөөдрийн хуралдаанаараа хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

“Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний Зөвлөлдөх санал асуулгын үр дүнгийн талаарх мэдээллийг Зөвлөлдөх зөвлөлийн зүгээс хийнэ.

Хоёрдугаарт, Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудлуудын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэх ёстой.

Зөвлөлдөх зөвлөлийн санал асуулгын дүнгээ танилцчихаад дараа нь Байнгын хороон дээрээ ярьж байгаад шаардлагатай гэж үзвэл Байнгын хорооноос Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төсөл гаргана.

Тэгвэл тэр дээр бас санал хураалт явагдах ёстой.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталъя. Ингээд ажилдаа орцгооё.

Нэг.Зөвлөлдөх санал асуулгын үр дүнгийн талаар мэдээлэл сонсох

“Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний Зөвлөлдөх санал асуулгын үр дүнгийн талаарх мэдээллийг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд Төрийн байгуулалтын байнгын хорооны өнөөдрийн хуралдаанд оролцох ажлын хэсгийн гишүүд оролцож байгаа.

Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа дарга ирсэн үү? Босоод харагдаад байгаарай гишүүдэд.

Үндэсний статистикийн хорооны дэд дарга Д.Лхамсүрэн, мөн хорооны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын дарга Ш.Ариунболд байна. Зөвлөлдөх зөвлөлийн гишүүн, дарга Г.Чулуунбаатар дарга байна. Б.Отгонтөгс гишүүн ирж амжсан уу? Арай ирээгүй байх шиг байна. О.Мөнхсайхан гишүүн, Н.Лувсанжав гишүүн Зөвлөлдөх зөвлөлийн ажлын албаны дарга. Мөн ажлын албаны гишүүн Ц.Товуусүрэн, Зөвлөлдөх зөвлөлийн ажлын албаны гишүүн, Нийслэлийн бодлогын шинжилгээ судалгааны төвийн Нийгэм, эдийн засгийн судалгааны газрын захирал А.Амарбал ирсэн байна. Зөвлөлдөх зөвлөлийн ажлын албаны гишүүн Г.Агар-Эрдэнэ. Г.Агар-Эрдэнэ дарга байгаа.

Мөн Ажлын албаны гишүүн Г.Золжаргал, О.Нарантуяа нар байна.

Г.Чулуунбаатар даргын микрофоныг өгье. 3 номерын микрофон. Санал асуулгын үр дүнгийн талаарх мэдээллийг сонсьё.

Г.Чулуунбаатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Ингээд “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний Зөвлөлдөх санал асуулгын дүнгийн талаарх танилцуулгыг Та бүхэнд хийе.

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатайгаар тодорхойлох, асуудлын эрэмбэ, шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх үндэсний зөвшилцлийг хангах зорилгоор “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний Зөвлөлдөх санал асуулгыг 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор зохион байгуулахаар Улсын Их Хурлын 80 дугаар тогтоолыг баталсан билээ.

Энэхүү тогтоолын дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 16 дугаар тогтоолоор Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулахад туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгээр ахлуулсан 10 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажилласан болно.

Улсын Их Хурлын 2022 оны 80 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнд нэр дэвшүүлэх хугацааг 12 дугаар сарын 23-ны өдрөөс 30-ны өдөр тогтоосон бөгөөд зөвлөлдөх шийдийн улсын хэмжээний санал асуулгыг удирдан зохион байгуулах Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнд оролцохоор материалаа ирүүлсэн 136 нэр дэвшигчээс 11 нэр дэвшигчийг Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэн нэр дэвшүүлж 01 дүгээр сарын 06-ны өдөр Улсын Их Хурлаас 11

гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулсан.

Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 9.2-т Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүн дотроосоо нэр дэвшүүлэн хуралдаанаараа хэлэлцэж даргыг сонгоно гэж заасны дагуу Зөвлөлдөх зөвлөлийн анхны хуралдаан 01 сарын 09-ний өдөр болж зөвлөлийн даргаар Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч Г.Чулуунбаатарыг. Мөн хуралдаанаар Зөвлөлдөх зөвлөлийн орлогч даргатай байхаар тогтож, эдийн засагч профессор Б.Отгонтөгсийг тус тус сонгосон болно.

“Зөвлөлдөж шийдье” санал асуулгыг Зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд заасны дагуу хоёр үе шаттай зохион байгууллаа.

Нэг дэх шатны санал асуулгыг Үндэсний статистикийн хороо хариуцан 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 02 дугаар сарын 02-ны өдрүүдэд орон даяар зохион байгуулж санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 1570 иргэн оролцсон бөгөөд үүнээс гадаад улсад ажиллаж амьдарч байгаа 8 иргэн цахимаар санал асуултад оролцлоо.

Хоёр дахь ёсны зөвлөлдөх уулзалтыг 2023 оны 02 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд Төрийн ордонд зохион байгуулсан бөгөөд нэг дэх шатанд оролцсон иргэний 50-иас доошгүй хувийг тохиолдлын зарчмаар сонгон авахаар заасны дагуу Статистикийн хорооноос санамсаргүй түүврийн аргаар хоёр дахь шатанд оролцох 801 оролцогч сонгогдон оролцсон болно.

Зөвлөлдөх санал асуулгын уулзалтыг нэгдсэн болон хэсгийн

Зөвлөлдөх зөвлөл нийт 10 удаа хуралдаж, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 8.12 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллалаа.

Зөвлөлдөх зөвлөл Төрийн байгуулалтын байнгын хорооны баталсан Зөвлөлдөх санал асуулгын ерөнхий төлөвлөгөө, түүнтэй уялдуулан Зөвлөлдөх зөвлөл Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын эрхлэх газар болон Үндэсний статистикийн хороо тус бүрийн баталсан нарийвчилсан төлөвлөгөөний дагуу “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгыг амжилттай зохион байгууллаа.

хэлэлцүүлгийн хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд нийт оролцогчид 15-аас илүүгүй хүнтэй 54 хэсэгт хуваагдан хэсгийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан юм.

Зөвлөлдөх санал асуулгын асуултыг Зөвлөлдөх зөвлөл 4 сэдвийн хүрээнд 22 асуулттайгаар баталсан.

Асуултыг бэлтгэхдээ Улсын Их Хурлын 2022 оны 80 дугаар тогтоолын хүрээнд зохион байгуулсан нийгэм, улс төр, эдийн засгийн тулгамдсан асуудал, гарц шийдэл, эрдэм шинжилгээний хурал, улс төр, эдийн засаг, эрх зүйн шийдэл, нийгмийн зөвшилцөл чуулга уулзалтаас гарсан санал, хөндөгдсөн асуудлууд болон Зөвлөлдөх зөвлөлөөс асуулт боловсруулах сэдвийн хүрээг тодорхойлж, иргэд, иргэний нийгмийн байгууллагаас цахим хэлбэрээр нээлттэй санал авсан бөгөөд нийт 25 санал ирүүлснийг Зөвлөлдөх санал асуулгын асуулт боловсруулахдаа нягтлан харгалзан үзсэн болно.

Зөвлөлдөх санал асуулгын асуултыг Төрийн байгуулалтын байнгын

хорооны 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүдээс асуултыг цөөлөх, чиглүүлсэн асуултуудыг иргэн авч үзэх, төсөвтэй холбоотой заалтуудыг хасах зэрэг саналууд гаргасныг Зөвлөлдөх зөвлөл хэлэлцэж “Зөвлөлдөж шийдье” зөвлөлдөх санал асуулгын асуултыг 4 сэдвийн хүрээнд 22 асуулттайгаар боловсруулан баталсан болно.

Улсын хэмжээний Зөвлөлдөх санал асуулгын асуултын лавлагаа, танилцуулга бэлдэх эсэхийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023 оны 7 дугаар захирамжаар 20 судлаачийн бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллалаа.

Лавлагаа танилцуулгыг ерөнхий мэдээлэл, өнөөгийн байдал, гадаад орны туршлага, эерэг, сөрөг тал гэсэн агуулгын хүрээнд сэдэв, асуултыг бүрэн хамарсан, мэдээлэл тэнцвэртэй, үнэн бодит байх зарчмыг баримтлан боловсруулсан болно.

Зөвлөлдөх санал асуулгын үйл явцын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлах ажлыг Улсын Их Хурлын Тамгын газар зохион байгуулж зөвлөлийн үйл ажиллагаа, гаргасан шийдвэрийн талаарх мэдээллийг зөвлөлийн гишүүд зохих хуваарийн дагуу мэдээж ажиллалаа.

Зөвлөлдөх санал асуулгын зарчим алдагдаж байгаа эсэхийг хяналт тавих ажлын хүрээнд Зөвлөлдөх санал асуулгын техникийн хяналтын комиссыг байгуулж ажиллах журмыг батлан ажиллуулсан.

Комисс Зөвлөлдөх санал асуулгын нэг дэх шатны мэдээлэл цуглуулалтад хяналт тавьж зөвлөлдөх уулзалтын үйл

ажиллагаанд хяналт тавин ажилласан бөгөөд Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах үеэр хууль журам зөрчсөн тохиолдол гараагүй.

Оролцогчид болон бусад иргэдээс гомдол, санал ирүүлээгүй болно.

Мөн зөвлөлдөх уулзалтад улс төрийн намын төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл болон олон улсын байгууллагын төлөөлөгчид ажиглагчаар оролцон ажилласан болно.

Үндэсний статистикийн хороо хоёр шатны санал асуулгын дүнг нэгтгэж тайлангаа Зөвлөлдөх зөвлөлд 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр хүлээлгэн өгсөн бөгөөд улсын хэмжээнд хоёр шаттайгаар зохион байгуулсан зөвлөл шийдвэрийн санал асуулгын дүнд үндэслэн гаргасан Зөвлөлдөх зөвлөлийн зөвлөмжийг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт хүлээлгэн өгсөн болно.

Зөвлөлдөх санал асуулгын асуулт тус бүрээр санал асуулгын дүнгийн тоон үзүүлэлтэд тулгуурласан зөвлөмжөө боловсруулж Улсын Их Хуралд хүргүүлсэн.

Зөвлөмжид Зөвлөлдөх санал асуулгын нэг ба хоёр дахь шатны дүнг нэгтгэсэн Үндэсний статистикийн хорооны тайланг хавсаргасан болно.

Мөн Та бүхэнд Зөвлөлдөх зөвлөлийн үйл ажиллагааны тайлан Үндэсний статистикийн хорооны Зөвлөлдөх санал асуулгын дүнгийн тухай тайлан, бусад холбогдох мэдээ материалыг тараасан байгаа.

Энэ удаагийн Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулж явуулсан туршлагаас үзэхэд санал асуулга явуулах сэдвийг хэт ерөнхий байдлаар тодорхойлсон. Тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх шийдлийн талаар үндэслэл бүхий хувилбарыг тусгаагүйн улмаас санал асуулгын асуулт, түүний шийдлийг тодорхойлоход Зөвлөлдөх зөвлөл болон шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн бүрэн эрх, чиг үүрэг тодорхой заагдаагүй байдал ажиглагдсаныг тэмдэглэж байна.

Иймд 2017 онд батлан мөрдөж буй Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн зохицуулалтыг цаашид боловсронгуй болгох шаардлагатай гэж үзсэн бөгөөд Зөвлөлдөх зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг Зөвлөлдөх зөвлөлийн үйл ажиллагааны тайланд оруулсан болно.

Мөн Зөвлөлдөх зөвлөлийн гишүүдээс “Зөвлөлдөж шийдье” санал асуулгаар хөндөгдсөн асуудлыг шийдвэрлэх, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах зэрэг үйл ажиллагаанд ажлын хэсэгт орж хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байгаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Г.Чулуунбаатар даргад баярлалаа.

Сая товч тайлан дотор бас дурдлаа. Зөвлөлдөх зөвлөлийн хийсэн ажлын тайлан, хоёр шатны санал асуулгын дүнг 02 сарын 17-ны өдөр Улсын Их Хурлын даргад албан ёсоор танилцуулсан. Энэ талаар мэдээллүүд явсан.

Дээр нь өнөөдөр нээгдсэн хаврын чуулганы нээлтийн хуралдаан дээр Улсын Их Хурлын дарга яг энэ

Зөвлөлдөх зөвлөлийн үйл ажиллагааны талаар явуулсан санал асуулгын дүнгийн талаар, тэрний дагуу хийгдэх ёстой ажлуудын талаар нэлээн дэлгэрэнгүй ярьсан. Олон нийт бас тодорхой хэмжээний мэдээлэл хүлээлтэй байгаа байх гэж бодож байна.

Ингээд сая Зөвлөлдөх зөвлөлийн даргын танилцуулсан зүйлтэй, танилцуулгатай холбогдуулаад асуух гишүүд байвал нэрсээ өгье.

Г.Занданшатар даргаар тасаллаа.
Б.Пүрэвдорж гишүүн асуултаа тавья.

Б.Пүрэвдорж: 2000-2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөр бас энэ Зөвлөлдөх санал асуулгыг орон даяар хийсэн л дээ.

Тэгээд би энэ дээр нэлээн сайн нарийвчилсан тоо баримтыг тухайн үед авч өөрийнхөө тойргийн иргэдтэй уулзах үедээ бас нэлээн сайн судалгаа хийгээд ингээд иргэдээс асуухад, мөн түүнчлэн сумын удирдлагуудаас асуухад яг нэг сум дээр, Цэцэг суман дээр байна уу даа хоёрхон хүн аймаг орж энэ зөвлөлдөх асуулгын асуулгад оролцсон гэж л гараа өргөж байсан юм. Гэтэл тухайн үед зуун хэдэн мянган хүн энэ Зөвлөлдөх санал асуулгад оролцсон гэдэг тийм л мэдээлэл ингээд явж байсан.

Тэгэхээр ер нь бол яах вэ, энэ Зөвлөлдөх санал асуулгын энэ зүйл бас нэг жоохон яг бүрэн иргэдийн дунд хүрч тэндээс яг тэр сум орон нутаг, багийн төлөөлөл болгож авч чадаж байна уу, чадахгүй байна уу гэдэг дээр бас эргэлзээ тухайн үед төрж байсан.

Тэгээд би сая хөдөө орон нутгаар ажиллаад хэдэн сум дээр мартчихсан байна лээ. Тэгээд би хоёр суман дээр

сумын даргаас нь энүүгээр Зөвлөлдөх санал асуулгын юм хум ирж хүн амьтан чинь оролцсон уу гээд нэг огцомхон асуухад ер нь тийм юм мэдэгдээгүй л гэж хоёр сумын дарга хэлсэн л дээ.

Тэгэхээр мянган хэдэн зуугаад. Мянган хэдэн зуу гэхив. 1570 хүн орсон гэхээр чинь энэ 330 сумаас нэг нэг хүн ядаж ормоор юм л гэсэн. Хоёр ч хүн юм уу. Тийм ээ. Хүн ормоор юм гэсэн тийм л статистик гармаар байдаг. Гэтэл хоёр суман дээр санасан дээрээ асуухад л байхгүй л байгаад байгаа юм л даа.

Тэгэхээр Үндсэн хуулийн өөрчлөлт чинь бүх одоо, орон нутаг, бүх бүс, бүх салбар, тэр газар нутгийн онцлогоос шалтгаалаад хүн болгоны санал бодол орох ёстой ийм л зүйл гэж би хараад байгаа юм.

Тийм учраас яг энэ аймаг, орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хүрээнд ямар шалгуураар яаж оролцуулаад байгаа юм бэ гэдэг. Тэгээд энэ дээрээ нэг тодорхой хариу өгөөч гэж хүсэж байна.

Н.Энхболд: Б.Батдаваа дарга хариулах байх. Энэ дээр энэ сонгуульд санал өгөхөд оролцсон хүмүүсийг сонгосон журам, аргачлал, үндэслэлийн талаар тайлбар өгөх хэрэгтэй болох нь ээ? Тийм 6 дугаар микрофон өгөөрэй.

Б.Батдаваа: Эрхэм гишүүн Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 11.5, 11.6-д заасны дагуу энэ санал асуулгын түүврийн арга зүйг боловсруулах ажлыг Үндэсний статистикийн хороо боловсруулж Зөвлөлдөх зөвлөлд танилцуулаад, энэ

түүвэрт оролцох нийт иргэдийн тоог зөвлөл батлах ийм зохицуулалттай байгаа.

Үндэсний статистикийн хорооны хувьд 01 дүгээр сарын 03-ны өдөр нийтдээ 30-аад их дээд сургуулиудын багш нар, эрдэмтэн, судлаач нартай хамтраад энэ түүврийн арга зүйн талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, түүврийн арга зүйгээ батлуулсан байгаа.

Түүврийн арга зүйн хувьд гэх юм бол ерөнхийдөө гурван шатлалтай санамсаргүй түүврийн арга явж байгаа.

Дотроо шатлалаар нь хуваах юм бол нэгдүгээрт Монгол Улсын засаг захиргааны нийт нэгжийг 1570 кластерт хуваачхаж байгаа. Эндээсээ 157 кластерыг санамсаргүй түүврийн аргаар сонгож байгаа гэсэн үг.

Энэ дотроосоо ахиад хоёрдугаар шатандаа түүврийн анхан шатны нэгжүүдээ. Дахиад энэ дотроо өрхүүдээ сонгож байгаа. Өрх дотроо шууд судлаач очоод мэдээлэл авахад хаалга тайлж байгаа хүн гэртээ байдаг, ажил эрхэлдэггүй хүн байх магадлалтай учраас **Kish Grid**¹-ийн арга ашиглаад өрхийн гишүүдэд дотроос бас санамсаргүй байдлаар тухайн өрхийн гишүүний аль ч иргэн сонгогдох магадлалтай байдлаар ингээд түүврийг зохиож байгаа гэсэн үг.

Тэгэхээр нийт 1570 нэгж маань санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон гэсэн үг. Ховд аймгаас гэхэд 40 иргэн нэгдүгээр шатандаа сонгогдож ажилласан байгаа.

¹ Статистикч, судалгааны арга зүйч [Лесли Киш](#) /Leslie Kish/-ийн боловсруулсан өрхийн судалгаанд оролцогчдыг санамсаргүй байдлаар сонгох арга.

Түүврийн арга зүйн хувьд 2017 онд явуулсан Зөвлөлдөх санал асуулгын түүврийн арга зүйтэй яг ижилхэн арга зүйгээр явуулсан. Баярлалаа.

Н.Энхболд: Болох уу? Б.Пүрэвдорж гишүүн ээ. Баярлалаа. Дараа нь санал хураана шүү. Б.Пүрэвдорж гишүүн ээ. Тогтоол гаргана шүү дээ. Тэр үед нь залгачихъя.

С.Бямбацогт гишүүн асууя.

С.Бямбацогт: Улсын хэмжээнд хоёр үе шаттай “Зөвлөлдөж шийдье” гэсэн улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулга явуулсан. Нэгдүгээр үе шат нь 1570 хүн 01 дүгээр сарын 26-наас 02 сарын 02-ны хооронд оролцсон юм байна.

Хоёрдугаар үе шатанд нь 801 хүн байсан уу? Тийм ээ. Оролцсон.

Мэдээж “бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй” гэж ярьдаг. Түүнтэй адилхан ард иргэдийнхээ саналыг сонсоод, Монгол Улс орны өмнө тулгамдсан нийгэм, эдийн засаг, улс төрийн чухал тулгамдсан асуудлуудыг ард иргэдийнхээ саналыг сонсож шийдэх гэсэн зорилго бол зөв өө. Ингэж бид хууль баталсан.

Үүний хүрээнд 2019 онд ч гэсэн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт хийсэн. Тодорхой үр дүн гарсан. Энэ удаагийн Зөвлөлдөх санал асуулгын үр дүн, ач холбогдол юу байв? Ямархуу үр дүн гарав? Одоо ямар асуудлууд дээр ард иргэд маань тулгамдсан гэж үзэв? Үүнийг нэг тоймлоод нэг товчхон бас нэг тодорхой манай зөвлөлийнхөн хэлээд өгөөч ээ гэсэн нэгдүгээр асуулт байгаа юм.

Хоёрдугаарт нь, энэ зөвлөлдөх санал асуулгын үр дүнгээр шинэ Үндсэн хууль ярих шаардлагагүй, хэлэлцэх шаардлагагүй. Үндсэндээ Үндсэн хуулийг шинэчлэн найруулах, хэлэлцэх шаардлагагүй гэсэн олонх нь үзсэн юм байна.

Харин нөгөө талдаа 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу батлан гаргах хуулиудыг хойшлуулшгүйгээр батлах, Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн үр дүнг үзье гэсэн ийм Зөвлөлдөх санал асуулгын үр дүн ингэж гарсан юм байна.

Энэ хүрээндээ Та бүхэн маань 2019 онд оруулсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд ямар хуулиудыг нэн тэргүүний ээлжид яаралтай хэлэлцэж батлах ёстой гэж үзэж байгаа вэ? Энэ дээр Та бүхэн бас өөрсдийнхөө байр суурийг илэрхийлээч ээ гэсэн хоёр дахь асуулт.

Гурав дахь асуулт нь, төвлөрлийг сааруулж бүсчлэн хөгжүүлэхтэй холбоотойгоор засаг захиргааны нэгжийн шинэчлэл хийхийг Та дэмжих үү гэсэн асуулт асуугдсан байна.

Энэ дүнг үндэслээд энэ асуултын хүрээнд Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулахын тулд орон нутагт оршин суугч болон шилжин суурьших иргэдэд тусгайлсан дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоё. Энд зөвхөн шилжин суурьшиж байгаа иргэд биш орон нутагт амьдарч байгаа иргэддээ бас дэмжлэг үзүүлэх ёстой. Ийм эрх зүйн орчин бүрдүүлэх ёстой гэж үзсэн байна. Энэ хүрээндээ бас засаг захиргааны шинэчлэл хийх саналыг боловсруулж Их Хурлаас шийдвэрлүүлье гэсэн саналыг Та бүхэн бас оруулж ирж байгаа юм байна.

Тэгэхээр энэ дээр тодорхой ямар саналууд байх вэ? Энэ дээр Та бүхэн нэг хариулт өгөөч ээ гэсэн гурав дахь асуулт.

Дөрөв дэх асуулт маань энэ хяналт шалгалттай холбоотой. Ард иргэдийг төлөөлөн ажилладаг төрийн хяналт шалгалтын бие даасан тогтолцоо бий болгохыг дэмжих үү гэсэн.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид төрийн Улсын Их Хурлын Хяналт шалгалтын түр хороо байгуулах, Хяналт шалгалтын түр хороогоор нээлттэй сонголт хийх, үүний дагуу 2020 онд Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг Их Хурлаар хэлэлцүүлж батлуулаад тодорхой үр дүнгээ өгөөд үндсэндээ өнөөдөр нийгэмд бугшсан энэ авлигалтай холбоотой, албан тушаалын ашиг сонирхолтой холбоотой олон бугшсан хууль бус зүйлүүд ил болж байгаа. Одоо нээлттэй сонголт ч хийж байна. Хөгжлийн банкны нээлттэй сонголт, нүүрсний хулгай нээлттэй сонголууд хийгдэнэ.

Тэгэхээр үүнээс өөр бүтэц байх ёстой юм байна гэж үзэж байгаа юм уу? Тийм ээ. Өөрөөр хэлэх юм бол ард иргэдийг төлөөлөн ажилладаг төрийн хяналт шалгах бие даасан тогтолцоотой болъё гэсэн дүн бас гарсан юм байна шүү дээ. Энэ дээр ингэж үзэж байгаа юу? Үүнийг хариулж өгөөч ээ.

Мөн албан тушаалтнуудын үндсэн хөрөнгө, орлогоо мэдүүлдэг. Тийм ээ. Төрийн албан хаагч хөрөнгө орлогоос гадна зарлагаа мэдүүлдэг байх. Зарлагаа. Ийм холбогдох хууль тогтоомжийг хийх нь зөв өө гэж үзсэн байна.

Тэгээд энэ хүрээндээ одоо бас ямар хуулиудыг яаралтай Улсын Их Хурал батлах ёстой вэ? Энэ дээр бас

ярьсан, хэлсэн зүйл байгаа юу гэсэн үндсэндээ таван асуулт асуучихлаа. Таван асуултад хариулт өгөөч ээ гэсэн.

Н.Энхболд: Г.Чулуунбаатар академич хариулна. Зөвлөлдөх зөвлөлийн дарга 3 номерын микрофон.

Г.Чулуунбаатар: Эрхэм гишүүн С.Бямбацогт гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр эхний гол үр дүн гэж хэлэх зүйлийг энэ дөрвөн үе шаттай. Үндсэндээ ард түмнийхээ санаа бодлыг дөрвөн үе шатаар дамжуулан зөвлөлдөж тодорхойлсон гол үр дүн нь байгаа болов уу гэж бодож байна.

Ер нь дөрвөн багц асуудлаар нэн тулгамдсан шийдвэрлэх ёстой гол чиглэлүүдийг гаргаж ирсний үр дүн гарсан гэж ойлгож болно. “Иргэний болон улс төрийн хариуцлага” гэсэн багц сэдвийн хүрээнд нийтийн 6 үндсэн асуудлыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай асуудал гэж үзсэн байгаа.

Энд тэр “жагсаал, цуглаан хийх хүрээний асуудлыг мэдээлэх журамд мэдэгдлийн зарчимд шилжих, зөвшөөрлийн зарчмаас үзэл бодлоо илэрхийлэх баталгаатай эрх зүйн орчныг бүрдүүлэх”.

Мөн “гадаад улсад суугаа иргэдийг Улсын Их Хурлын сонгуульд оролцуулах” гэх мэтчилэнгийн.

Саяын таны тэр дөрөвдүгээрт асуусан “иргэдийг төлөөлөн ажилладаг төрийн хяналт шалгалтын бие даасан тогтолцоо бий болгох” зэрэг ийм зургаан асуулт тодорсон. Парламентын ардчиллын хүрээнд бас 6 асуудал байгаа.

Энэ дотор “Улс төрийн намын тухай”, “Сонгуулийн тухай хууль” гэх мэтчилгийн гол хуулиудын тухай асуудлууд.

Эдийн засаг, баялгийн сан, төвлөрлийг сааруулах хүрээнд мөн таны саяын асуусан асуултуудыг багтаасан “Баялгийн сангийн хууль”, түүний удирдлагын тогтолцоо, “Төв банкны хараат бус байдал” зэрэг асуудлууд.

Нийгмийн салбарт бол 3 тулгамдсан асуудлыг тодруулсан гол үр дүн гарсан гэж хэлж болно.

Тэр хоёр дахь асуулт нь, Үндсэн хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай юу гэсэн асуулт байгаа юм.

Тэгээд энэ бол эхний санал асуулгын дүнгээр 0.6 орчим хувийн саналын дэмжлэгтэй. Хоёр дахь хэлэлцүүлэг дээр 0.4 болж, дунджаар дэмжлэг аваагүй байгаа.

Шинээр 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлах хүрээнд Улсын Их Хурлын сонгуулийн хуулийг холимог тогтолцоонд шилжүүлэх, парламентад ард иргэдийг төлөөлөх чадавхыг нэмэгдүүлэх тухай асуудал болон Намын санхүүжилтийн тухай, Баялгийн сангийн тухай зэрэг ийм гол гол хуулиудыг ойлгож мэдээлэлд тусгасан байгаа. Тийм. 2 дугаар тогтоолд байгаа.

Энэ төвлөрлийг сааруулахтай холбоотой асуудлаар мөн захиргааны шинэтгэлийг эхлүүлэх, орон нутагт ажиллаж амьдарч байгаа болон тийшээ шилжих гэж байгаа хүмүүст дэмжлэг үзүүлж байгаа төрийн бодлогыг дэмжих шаардлагатай гэсэн зүйл тодорхойлогдсон байгаа.

Хяналт шалгалтын тогтолцоо гэдэг бол одоогийн бие даасан тогтолцоо гэдэг утгаар одоогийн тогтолцоог боловсронгуй болгож төгөлдөржүүлээд Азийн эрх зүйн системд нэлээн түгээмэл хэрэглэгдэж ирсэн уламжлалтай тэр биеэ даасан иргэдийн оролцоотой тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай гэсэн санаагаар асуулт яригдсан.

Энэ бүхнийг зүгээр Зөвлөлдөх санал асуулгын асуултад шууд тусгаж яг миний задаргаа тайлбартайгаар бол тусгаж оруулаагүй. Харин нөгөө эрдэм шинжилгээний хурлын хэлэлцүүлэг.../минут дуусав/

Н.Энхболд: 3 дугаар микрофоныг жаахан тавиухан өгчхөөрэй. Дараа нь С.Бямбацогт гишүүн тодруулья.

Г.Чулуунбаатар: Тодорхой саналууд дээрээс үндэслэж тусгаж байгаа.

Н.Энхболд: Г.Чулуунбаатар захирал аа, та түр хүлээж байя. С.Бямбацогт гишүүн тодруулчихъя гэнэ.

Тэгээд тэр тодруулсантай нь нэмээд түрүүчийнхийг гүйцээгээд хариулчих. Тийм. С.Бямбацогт гишүүний микрофон.

С.Бямбацогт: Тийм. Г.Чулуунбаатар гуай та тодорхой хариулчихмаар байгаа юм.

Би их тодорхой асуусан. Зорилго маань зөв байсан. Ард иргэдтэйгээ бүгдээрээ хэлэлцээд явах нь зөв өө. Тэгээд хэр үр дүн гарав. Ямар ач холбогдолтой болов. Энэ дээр та нэг тоймлоод базаад л хариулаад өгөөч ээ гэсэн. Нэг.

Хоёрдугаарт нь, тодорхой дөрвөн асуудал дээр ийм үр дүн гарсан юм байна, ард иргэд маань ингэж үзэж байгаа юм байна. Үүний дагуу ямар гарц, шийдлүүдийг Улсын Их Хурал хууль эрх зүйн хүрээнд хийх бололцоотой вэ? Энэ дээр Та бүхэн ямар саналтай байна вэ гэдгийг л хариулаад өг гэсэн л дөө. Би зүгээр энэ тайлангаа уншиж байгаад тавиадах гэсэнгүй.

Нэмэлт бусад хүмүүс нь хариулж болно шүү бас.

Н.Энхболд: 3 номерын микрофон.

Г.Чулуунбаатар: Гол үр дүнг бол дөрвөн багц асуудлаар ард түмний хүлээж байгаа хүлээлт, шийдэх асуудлын эрэмбэ тодорхойлогдсон л гэж хураангуйлж хэлмээр байна.

Тэр дараагийн дөрвөн асуултын тухайд Зөвлөлдөх зөвлөл яг ийм хуулийг ийм агуулгаар ингэж шийдэх шаардлагатай, бололцоотой гэдэг зөвлөмжийг гаргах боломжгүй. Энэ асуудлыг яаж шийдэх нь Их Хурлын бүрэн эрхийн хүрээний асуудал юм гэж ойлгож байгаа.

Зөвлөмжийн төгсгөл дээр хамгийн сүүлийн өгүүлбэрт Зөвлөлдөх санал асуулгын бүх процессын явцад хуримтлагдсан мэдээллийн санд нарийвчилсан дүн шинжилгээ хийж, судалгаа хийж, энэ зөвлөмжийн заалт бүрээр ямар хуулиудыг ямар үзэл концепцын дагуу ямар зарчмаар хийх нь зүйтэй вэ гэдгийг тодруулах шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байгаа.

Зөвлөлдөх зөвлөл бол яг тодорхой асуудлаар ийм хуулийг ийм агуулгаар

ингэж явуулья гэдэг зүйлийг хэлэх бололцоо байхгүй гэж ойлгож байгаа. Гишүүд нэмж хариулах бол би нэмэх зүйлгүй байна.

Н.Энхболд: Нэмэх үү? Гишүүдээс. О.Мөнхсайхан доктор. 5 номерын микрофон.

О.Мөнхсайхан: Нэмж хариулья. Тэгэхээр энэ удаагийн Зөвлөлдөх санал асуулга бол өөрөө нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудал, шийдэл гэсэн маш өргөн хүрээтэй ийм агуулгаар явагдсан. Их Хурлын тогтоол тэгж гарсан.

Тэгээд Зөвлөлдөх зөвлөлийн хувьд өмнө нь зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хурал, чуулга уулзалт, бусад судалгаа зэрэг дээр үндэслээд шигшсээр байгаад ерөнхийдөө 4 чиглэлийн 22 асуултыг иргэдэд танилцуулж, дэмжиж байгаа, дэмжээгүйгээр нь ингээд асуусан байгаа юм.

Энэ дотроо иргэдийн хувьд Үндсэн хуулийг шинэчлэн найруулах хэрэгтэй гэдгийг ерөөсөө дэмжээгүй.

Харин 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийнхөө дагуу гарах тэр хуулиудыг хойшлуулшгүй яаралтай баталж, үр дүнг нь үзээч ээ гэдэг энэ байр суурь давамгайлсан.

Энэ дотроо С.Бямбацогт гишүүний асуусанчлан Улсын Их Хурлын 2000 оны 2 дугаар тогтоолд зааснаар 20 гаруй хууль 2019 оны нэмэлт, өөрчлөлтийг дагаж гарах ёстой. Гэтэл одоог хүртэл Шүүхийн тухай, Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай зэрэг цөөн хуулиуд гараад бас үр дүнгээ үзэж байгаа боловч 15 хууль өргөн баригдаагүй байгаа юм.

Тухайлах юм бол Үндсэн хуулийн 33.4-д заасны дагуу Ерөнхийлөгчид Үндсэн хуульд зааснаас өөр бүрэн эрх өгөхийг хориглосон байгаа.

Тэгэхээр энэ заалтыг биелүүлэх ажил бүрэн хийгдээгүй. Ерөнхийлөгчийн тухай хууль Хууль зүйн яаман дээр боловсруулагдаад бэлэн болчихсон боловч өргөн баригдаагүй байж байгаа.

Мөн Улс төрийн намын болон Улс төрийн санхүүжилтийн тухай хуулийн төслийг Ц.Мөнхцэцэг гишүүн ахлаад боловсруулсан. Ерөнхийлөгч дээр бас сайжруулалт хийгдэж байгаа.

Тэгээд энэ бол яг л 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу манай өнөөдрийн нийгмийн суурь асуудлууд шийдэгдэж чадахгүй байгаа нь энэ улс төрийн санхүүжилттэй холбоотой, улс төрийн намын дотоод ардчилал алдагдаж иргэдэд итгэл хүлээх байдал нь суларсан. Үүнийг шийдэх ийм зохицуулалт орсон.

Тэгэхээр улс төрийн намын болон санхүүжилтийн хуулийн төсөл өргөн баригдаагүй байна. Тухайлах юм бол 2016 онд Улсын Их Хурлын сонгуульд 33.4 тэрбум төгрөг нийт зарцуулж байсан албан тоо байгаа бол 2020 онд энэ нь 75 тэрбум болж хоёр дахин өссөн.

Нэр дэвшигчид, намууд зардлын тайлангаа ерөөсөө гаргаж өгдөггүй. Өгөхгүй байгаа тохиолдолд олон зуун сая төгрөгийн зөрчил гаргасан ч гэсэн 10-хан сая төгрөгөөр нэр дэвшигч торгуулдаг. Тэгээд гаргаж өгч байгаа тайлан нь маш ерөнхий учраас яг хаанаас мөнгө аваад зарцуулсан гэдэг нь тодорхойгүй. Гэх мэтчилэн олон зүйлүүдээс болоод маш хяналтгүй мөнгө эргэлдэж байгаа нь

өөрөө энэ авлигын цаад суурь шалтгаан юм.

Тэгэхээр үүнийг шийдвэрлэх Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн дагуу олон улсын сайн туршлагыг тусгасан ийм төсөл бэлэн болчихсон. Өргөн баригдаагүй.

Мөн яг Зөвлөлдөх санал асуулгын асуултад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу баялгийн санг байгуулах хэрэгтэй юу. Ингэхдээ яаж байгуулах вэ гэдэг асуулт бас тавигдсан.

Энэ дээр иргэд энэ баялгийн сангийн удирдлагыг хараат бус мэргэжлийн олон нийтийн оролцоотой байлгаж өгөөч ээ гэдэг энэ зарчмын саналыг дэмжсэн. Харамсалтай нь одоог хүртэл бас энэ хуулийн төсөл өргөн баригдаагүй, энэ сан байгуулагдаагүй байна.

Мөн 2019 онд оруулсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг харьцангуй уян хатан байдлаар иргэдийнх нь саналыг аваад Засгийн газрын өргөн мэдүүлснээр өөрчлөх ийм боломжтой болсон.

Тэгэхээр энэ арга замыг ашиглаж төвлөрлийг сааруулах хэрэгтэй гэдгийг иргэд дэмжсэн. Гэвч энэ санал бол.../минут дуусав/

Н.Энхболд: 5 дугаар микрофон. 1 минут нэмчих.

О.Мөнхсайхан: Товчхондоо 2020 оны Улсын Их Хурлын 2 дугаар тогтоолын дагуу гарах ёстой 15 хуулиа хойшлуулшгүй боловсруулж батлах ийм шаардлагатай гэж харж байгаа.

Энэ дээр нэмээд хэлэхэд энэ Зөвлөлдөх санал асуулга бол ерөнхийдөө энэ 22 чухал асуудлаар иргэд алиныг нь дэмжиж байгаа юм, дэмжихгүй байгаа юм гэдэг байр суурийг нь тэнцвэртэй мэдээлэл өгч авсан.

Үүнээс цаашаа юу хийх вэ гэдгийг Улсын Их Хурал буюу шийдвэр гаргах эрх бүхий этгээд маань ажлын хэсэг гаргаж, зарим дээр нь Засгийн газар ажиллаж яг тухайн хуулийн төслөө боловсруулахдаа мэргэжлийн хүмүүсийг нь оролцуулах, улс төрийн хүчнүүдийн хувьд зөвшилцлийг хангах. Дахиад тэр гарч ирсэн төслийнхөө хувилбар дээр нэмж иргэдээс санал авах байдлаар энэ процесс үргэлжилнэ гэж харж байгаа.

Зарим хүмүүс зөвлөлдөх санал асуулгад хүссэн иргэн орж чадахгүй байна. Тохиолдлоор сонгогдсон 1500 хүн орчхоод байна гээд шүүмжилдэг.

Тэгэхээр энэ бол процессын зөвхөн нэг хэсэг.../минут дуусав/

Н.Энхболд: Дутуу байвал дараа нь. С.Бямбацогт гишүүн дахиад нэг асуучих.

С.Бямбацогт: Тэр төвлөрлийг сааруулах асуудал дээр Ц.Товуусүрэн гуай нэлээн тодорхой.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд орон нутгийн засаглалыг бэхжүүлэхтэй холбоотой, төвлөрлийг саруулахтай холбоотой асуудал дээр нэлээн анхаарч ажиллаж байсан хүний хувьд энэ удаагийн Зөвлөлдөх санал асуулгын 2019 оныхтой харьцуулахад ямархуу өөрчлөлтүүд байна, үр дүн ямархуу гарсан бол. Цаашид бид ямар шийдэл байвал дээр гэдэг дээр Та нэг хариулт өгөөч ээ гэж хүсье.

Хоёрдугаарт нь, Н.Лувсанжав гуай.

Тэр ард иргэдийг төлөөлөн ажиллах төрийн хяналт шалгах бие даасан тогтолцоо бий болгохыг дэмжсэн байна л даа. Энэ Зөвлөлдөх санал асуулгын үеэр.

Бид чинь 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуультай болсон. Улсын Их Хурал дээр Хянан шалгах түр хороо ажилладаг болсон.

Үүнээс гадна Үндэсний аудитын газар гээд төрийн санхүү, төсвийн хяналтыг аудитын байгууллага хийнэ гээд аудитын байгууллагыг Үндсэн хуулийн байгууллага болгосон. Үүний үр дүнг хаачих бол, яах бол?

Н.Энхболд: Хариулъя. Ц.Товуусүрэн гуай эхлээд хариулчихъя. 1 номерын микрофон.

Ц.Товуусүрэн: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Тэгэхээр төвлөрлийг сааруулах асуудал.

Зөвлөлдөх зөвлөлд ямар шийдэл гаргах вэ гэдэг тийм бүрэн эрхийг хуулиар олгоогүй л дээ. Хуулиар Зөвлөлдөх зөвлөл Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулаад, зөвлөмжөө гаргаад шийдвэр гаргадаг этгээдэд өг гэсэн ийм юм.

Миний нэрийг дурдаад нь миний байр суурийг асууж байгаа бол би өөрийнхөө байр суурийг хэлье.

Ямар ч байсан Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг маш

яаралтай гаргаад, тодорхой тийм хөдөө суурин газруудад амьдрах боломжийг бүрдүүлэх ёстой гэж ингэж бодож байна.

Ер нь төвлөрлийг сааруулах асуудлаар би нэг их тийм биечлэн судалж нарийвчлан үзсэн юм бол ховорхон. С.Бямбацогт гишүүн намайг судалдаг гэж ойлгож байх шиг байна. /минут дуусав/

Н.Энхболд: Хариултууд 4 минутад багтаана. Шаардлагатай бол 1 минут нэмэх ёстой. 1 минут нэмээд өгчихье. Тийм. Болчихсон уу?

Н.Лувсанжав дарга. 2 номер.

Н.Лувсанжав: Энэ Зөвлөлдөх санал асуулга бол угаасаа энэ санал асуулгын асуултыг боловсруулах явцад шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн саналыг тусгаж, тэр үндсэн дээр энэ асуултууд гарч ирсэн байгаа юм. Тэр зарчмаараа энэ асуулт орж ирсэн асуулт байгаа юм л даа.

Ер нь С.Бямбацогт гишүүний хэлж байгаа Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн дагуу нэлээн дорвитой хяналтын асуудлыг хөндөж шийдсэн тодорхой Үндсэн хуулийн шийдлүүд байгаа л даа.

“Төрийн төсөв, санхүүгийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны журам, зарчмыг хуулиар тогтооно” гэдэг заалт 2019 оны нэмэлтээр орж ирж. Угаасаа энэ заалтыг оруулахдаа ажил.../минут дуусав/

Н.Энхболд: 1 минут нэмээд өгье. 2 дугаар микрофон дээр.

Н.Лувсанжав: Үүний цаана төрийн аудитын байгууллага байгаа шүү

гэдэг энэ агуулгаар энэ заалтууд батлагдсан.

Төрийн аудитын тухай хууль бас шинэчлэгдэж батлагдсан. Гэхдээ шинээр энэ асуулт орж ирсэн маань эргээд энэ хяналтын тогтолцоог илүү олон талыг нь хамарсан бүрэн эрхтэй ийм тогтолцоо бий болгох нь зүйтэй л гэсэн ийм байдлаар дүн гарч байна гэж ингэж ойлгож байгаа юм.

Яг энд ямар зарчмаар ямар байгууллагыг байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх вэ гэдгийг шийдвэр гаргах эрх бүхий этгээд болоод Их Хурал тодорхойлох ёстой. Энэ асуудлаар бодвол ажлын хэсэг гарч нэлээн судалж байж асуудлыг ямар хүрээнд шийдэх вэ гэдгийгээ тодорхойлох болов уу гэж ингэж бодож байна.

Н.Энхболд: Баярлалаа. Ц.Мөнхцэцэг гишүүн асууя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр улсын хэмжээнд хоёр дахь удаагаа иргэдийн шууд ардчиллын нэг хэлбэр болж байгаа Зөвлөлдөх санал асуулга явуулаад үр дүн гарсан байна.

Тэгэхээр энэ Зөвлөлдөх санал асуулгаар манай оролцсон иргэд маш дэвшилттэй эрх зүйн шинэчлэлүүдийн саналыг гаргасан байна. Үүнд миний хувьд сэтгэл ханамжтай байна. Тухайлбал, “иргэний улс төрийн эрхийг бэхжүүлэх”, “сонгуулийн зардлыг бууруулах”, “улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох”, мөн “баялгийн санг байгуулж, нийгмийн тэгш бус байдлыг багасгах” зэрэг иймэрхүү асуудлаар иргэд маань маш сайн байр сууриа илэрхийлж, зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг мөн бид үзэж харж байна.

Тэгэхээр иргэдээс өгсөн саналуудын дагуу манай Улсын Их Хурлын гишүүд бид ажиллаж, ялангуяа улс төрийн авлигыг бууруулах, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх чиглэлээр улс төрийн намын болон сонгуулийн хуулиуд дээр яаралтай ажиллах ёстой гэдэгтэй санал нэг байна.

Миний хувьд Улс төрийн намын тухай хууль, Санхүүжилтийн хуулийн ажлын хэсгийг ахлан ажиллаж байна.

Тэгээд Зөвлөлдөх зөвлөлийн гишүүдээсээ хоёр асуулт байна.

Зөвлөлдөх зөвлөлийн санал асуулгад асуугаад явсан байгаа 303 дугаар асуулт байгаа юм. **“Иргэдээ төлөөлөх парламентын чадавхыг нэмэгдүүлж төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх хэрэгтэй гэдэгтэй та санал нийлж байна уу?”** гэж.

Энэ уг нь агуулгыг хэрвээ өргөн утгаар ойлговол их сайн асуулт байгаа. Тэгэхдээ асуултад ингээд орчихсон байдлаас харахад маш ерөнхий, салаа утгатай байж болохуйц харагдаж байгаа юм. Үүнийг зөвлөлдөх санал асуулгын энэ хоёр шатанд Та бүхэн маань иргэдэд хэрхэн тайлбарлаж агуулгыг тодорхойлж байсан бэ?

Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүний хувьд, тухайлбал миний хувьд иргэдийн төлөөлөх парламентын чадавх гэдэг парламент нийгмийн бүтцийг болон хүн амын төлөөллийг хангалттай төлөөлөх ёстой.

Монгол Улсын хувьд хүн ам цөөтэй, өргөн уудам нутагтай учраас мөн газар нутгийн төлөөллийг ч гэсэн тэгш хангах ёстой.

Ер нь өргөн утгаар парламентын гишүүний тоог нэмэх нь зөв гэдгээр энэ иргэдийн төлөөлөх парламентын чадавхыг ойлгож байгаа. Тэгвэл яг Зөвлөлдөх санал асуулгын үед иргэдэд үүнийг яг ямар агуулгаар тайлбарласан бэ? Иргэдийн дунд энэ талаар асуултууд бүрхэг байсан байх.

Хоёрдугаар асуулт нь, Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлаар Зөвлөлдөх зөвлөлийн санал асуулгуудыг бид хэлэлцсэн. Тухайн үед байсан зарим нэг дэвшилттэй асуултууд Зөвлөлдөх зөвлөлийн асуулгад ороогүй хасагдаад явчихсан байгаа. Тухайлбал хүний эрхтэй холбоотой, жендерийн тэгш эрхтэй холбоотой, мөн нийгмийн томоохон шинэчлэл болох боловсролын шинэчлэлтэй холбоотой хэд хэдэн асуулт байсан. Энд хасагдсан байна.

Жишээлбэл, тэр **“Эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн тэгш эрх хэр хангагдаж байгаа гэж та үздэг вэ?”**, **“Нийгмийн тэгш бус байдлыг багасгахын тулд боловсрол ашгийн бус байх ёстой юу гэдгийг Та юу гэж үзэж байна?”** гэх мэтээр ийм нийгмийн шинэчлэлийн, хүний эрхийн гол асуудлууд хасагдсан байгаа.

Энэ яаж явж байгаад хасагдсан бэ? Аль түвшиндээ хасагдсан?

Ер нь иргэдээс бид нийгэм, эдийн засаг, эрх зүй, улс төрийн шинэчлэлийг хэрвээ өргөн хүрээнд асууж байгаа бол саяын дурдсан реформын шинжтэй, ялангуяа боловсролын асуултууд уг нь байх ёстой байсан.

Хүний эрхийн, тэр жендерийн эрхийн асуудал ч гэсэн ер нь байх ёстой байсан. Эд нар маань ингээд яагаад

хасдаад явчихсан юм гэдэг дээр Зөвлөлийн бүрэлдэхүүнээс хариулт авмаар байна.

Н.Энхболд: 3 дугаар микрофон. Г.Чулуунбаатар академич.

Г.Чулуунбаатар: Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Тэр 305 дугаар асуулт буюу “Парламентад иргэдийг төлөөлөх, чадавхыг нэмэгдүүлэхийг Та дэмжиж байна уу” гэсэн асуултыг Төрийн байгуулалтын байнгын хорооны 01 сарын 17 билүү, хуралд оруулахдаа бид арай жаахан задаргаатай оруулсан байсан юм.

Тэгээд Байнгын хорооны гишүүд тодорхой саналууд хэлснийг үндэслээд ийм ерөнхий томъёолол руу оруулсан.

Зүгээр Зөвлөлдөх санал асуулгын хоёр дахь шат буюу зөвлөлдөх уулзалтад оролцсон хүмүүст хүргэсэн мэдээлэл дотор энэ асуултын агуулгыг нэлээн дэлгэрүүлж тавьсан байгаа.

Сая таны хэлж байгаа тэр орон нутгийг болон хүн амын кластерыг төлөөлөхөөс гадна, ер нь парламент иргэдийг төлөөлөх чадавхыг нэмэгдүүлэхэд гишүүдийн тоог нэмэх тухай асуудал байж болно. Бас сонгуулийн системээ боловсронгуй болгоод улс төрийн намуудын үзэл бодлын төлөөллийг бүрэн оролцуулах тийм бололцоог бас хангаж болно. Улс төрийн намууд нэр дэвшигчдээ тавих шалгуур, төлөөллийн зарчмуудыг нь нарийвчлаад бас чанаржуулах замаар төлөөллийн чадавхыг сайжруулж болно гэх мэтчилэнгийн тодорхой асуудлуудыг энэ мэдээлэлд оруулж, мөн зөвлөлдөх уулзалтын үеэр мэдээлэл хийсэн гишүүд, шинжээчид бас ийм чиглэлээр мэдээлэл

өгсний үндсэн дээр асуултад хариулт авсан байгаа.

Цаад агуулга нь миний саяын хэлдэг ерөнхий агуулгатай ийм зүйл байгаа юм.

Ер нь дэмжлэгийн хувьд 22 асуултыг эрэмбэлээд үзэхэд дундаж хэмжээнд эрэмбэлэгдсэн асуулт байгаа.

Хоёр дахь асуултын тухайд 01 сарын 17-ны Төрийн байгуулалтын байнгын хороонд зөвлөл асуултын төслийг оруулахад 60 асуулт орсон. Гишүүд маш тодорхой саналууд хэлсэн.

Тэр бүх саналуудыг нэг бүрчлэн авч үзээд Зөвлөлдөх зөвлөлийн гишүүд нөгөө 4 багцалсан багцаараа анх асуудал оруулсан гишүүдээр нь үндэслэл тайлбаруудыг нь хэлүүлж байгаад, тал талаас нь ярилцаж байгаад санал хурааж, гар өргөх зарчмаар асуултуудыг хасахыг нь хасаад, томъёоллыг нь өөрчлөхийг нь өөрчлүүлээд, өөрчлөгдөөд явсан. Энэ явцад гар өргөж санал хураалтын дүнгээр хасагдаад явчихсан байгаа юм.

Ер нь боловсролын хүрээний шинэчлэлийн асуудал, нийгмийн салбарын зарим гол асуудлуудыг дахиж гүнзгийрүүлэн судлах шаардлагатай гэсэн бодол хувь хүний хувьд байдаг. Баярлалаа.

Н.Энхболд: Тодруулах уу, болсон уу? Баярлалаа. Г.Занданшатар дарга.

Г.Занданшатар: Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Тэгээд юуны өмнө энэ их түүхэн үйл хэрэг. Ард иргэдийн санал бодлыг тандан судлах, тодорхой нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг

тодорхойлох талаар манай Зөвлөлдөх зөвлөл бас идэвх санаачилгатай ажил хэрэгч ажилласан явдалд талархал илэрхийлье.

Тэгэхдээ одоо огцом асуугаад, гэнэт санаад бүх нутаг дэвсгэрийн бүх сумын төлөөлөл ч юм уу, оролцох бололцоогүй л дээ. Яагаад гэхээр Монгол Улсын бүх иргэн л оролцох ёстой гэж үздэг. Ардчилал бол. Бүх иргэнийг л оролцуулах шаардлагатай байдаг. Бүх иргэн сонгогдох магадлал байгаа.

Тэгээд тэр нь санамсаргүй түүврээр эрэмбэлэгдээд л нийгмийн бүлэг кластер хэчнээн малчдын төлөөлөл хамгийн том бүлэг кластер байгаа бол тэд хувь, процентоороо тэгээд ангилагдаад л нас, хүйс бүх юмаараа л төлөөлж чадахуйц төлөөлөл бол бий болсон байх гэж бодож байна.

Зүгээр энд нэг тодруулах л асуулт байгаа нь 2023 оны Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах тухай 02 дугаар тогтоол дээр Улсын Их Хуралд танилцуулахыг гэж чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар заачихсан байна уу?

Тэгэх юм бол тогтоол Байнгын хорооны тогтоол гарах ёстой юу, Улсын Их Хурлын тогтоол гарах ёстой юу гэдгийг ажлын хэсэг, манай Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаныхан бас хэлээд өгчихмөөр байна.

Хэрвээ Улсын Их Хурлын тогтоол шаардлагатай гэж үзвэл тогтоол болгоод Байнгын хорооны тогтоолоо өөрчлөөд оруулчих бол асуудал гарах уу, үгүй юу? Зүгээр тогтоол дээрээ Улсын Их Хуралд танилцуулна гэж заахыг зүгээр Байнгын хороонд танилцчихвал илүү аль болох байх.

Ер нь зүгээр тэр С.Бямбацогт гишүүний асуусан асуулттай холбоотой Зөвлөлдөх зөвлөлийн зарим гишүүд тэр Ардын хянан шалгах хороог сэргээн байгуулах, зарим нь Азийн Үндсэн хуулийн эрх зүйн чиглэлээр байдаг тэр Төрийн хяналт шалгалтын хороог сэргээн байгуулах. Тэнд ёс зүйн хороо ч байдаг, төрийн аудит ч байдаг тийм бие даасан Үндсэн хуулийн байгууллага, тогтолцоо бий болгох. Авлигатай тэмцэх болон төсөв мөнгөний хяналтыг сайжруулах чиглэлээр ийм агуулгаас энэ санаа гарсан гэж ойлгосон. Тийм өнцгөөр асуулт, хариулт явагдсан. Жижиг бүлгийн хэлэлцүүлгүүд хийгдсэн гэж ажигласан.

Бас нөгөө нэг хувилбар нь бол яах вэ одоо Европын Үндсэн хуулийн гэдэг юм уу, Англисаксоны ч бай Үндсэн хуулийн эрх зүйд байгаа тэр төрийн хариуцлагын тогтолцоо бий болгох. Тэр нь парламентын хажууд байж болно. Энэ нээлттэй сонголд Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийг илүү институцчилж, боловсронгуй болгох, институцтэй болгох ийм агуулгууд байгаа. Хоёр, гурван хувилбар байгаа гэж үзэж байгаа. Тэгээд тэр хоёр, гурван хувилбар чиглэлээр нь Улсын Их Хурлын Тамгын газар судалгаа хийж ажиллаж байгаа. Азийн улсуудын Үндсэн хуулиас болон хуулийг нь судалж үзэж байгаа.

Тэгээд энэ бол бас иргэдийн хамгийн өндөр хувиар тэмцэж байгаа, бүх асуудалтайгаа холбогдож яригдаж байгаа асуудал учраас энэ чиглэлээр Төрийн байгуулалтын байнгын хорооноос дэлгэрэнгүй тодруулж ярилцах нь зүйтэй байх. Энд нөгөө санал гаргасан Зөвлөлдөх зөвлөлийн гишүүд нь байхгүй байгаа учраас. Д.Моондой гуай, Л.Төр-Од нар энэ талаар нэлээн. Ө.Ганхуяг гуайн нар нэлээн дэлгэрэнгүй

санал гаргасан. Тэр С.Бямбацогт гишүүний яриад байгаа.

Ер нь Авлигатай тэмцэх газар ч гэсэн Үндсэн хуулийн байгууллага гэж хараат бус байдлыг нь хангах нөхцөл байдлыг төрийн аудит шиг тусгаж болох шаардлагатай байж болно.

Төрийн аудитыг зүгээр хараат бус, төсөв, мөнгөний хяналт байна гэж Үндсэн хуулийн тэр нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаа бол бас бүрэн тусаагүй юм билээ. Сүүлд нь Төрийн хяналт шалгалтын хууль харсан чинь зүгээр л нийцлийн аудит, тайлан тэмцлийн аудит хийдэг болчихсон.

Хуучин 2003 онд хүчингүй болгочихсон Төрийн хяналт, шалгалтын тухай хуулиар Төрийн хяналт шалгалтын хороо бол бас нэлээн тийм өргөн эрх үүрэгтэй. Энэ төрийн өмчийн компаниудын хараа хяналт их сайн байсан. Тендер бүх юмыг үздэг байсан.../минут дуусав/

Н.Энхболд: 1 минут нэмчихье. Г.Занданшатар даргын микрофоныг.

Г.Занданшатар: Тэгээд 2003 онд Төрийн хяналт шалгалтын хороог татан буулгаад төрийн аудитын байгууллага болгосон протокол, процессыг үзэхээр тухайн үед хэтэрхий их хяналттай байна.

Засгийн газар төсөв, мөнгөний хяналт дээр хяналтыг сулруулсан. Тэгээд мэргэжлийн хяналт, төрийн аудит хоёр дунд асуудал хаягдсан. Тэр нь бас өнөөдрийн энэ төрийн өмчийн компаниудын хяналтгүй, дураараа авирах, төсөв мөнгөний хяналт алдагдах ийм боломжийг бүрдүүлсэн гэсэн ийм дүгнэлт бас байдаг.

Тийм учраас үүнийг тэр хэмжээнд нь нэлээн сайн судалж үзэх шаардлагатай юм байна лээ гэж үзэж байна.

Энэ талаар манай Н.Лувсанжав гуай, Ц.Товуусүрэн гуай нар ч бас ажиллаж байгаа байх. Тэр талаар тодруулж ярих уу.

Тэгээд О.Мөнхсайхан доктор энэ талаар ер нь юу гэж бодож байна? Асуучихъя даа.

Н.Энхболд: 5 номерын микрофон. Доктор О.Мөнхсайхан.

О.Мөнхсайхан: Тэгэхээр Зөвлөлдөх санал асуулгаар ард иргэдийг төлөөлөн ажилладаг төрийн хянан шалгах бие даасан тогтолцоог бий болгохыг дэмжсэн байгаа.

Тэгэхээр үүний цаад санаа бол сая Г.Занданшатар даргын хэлдгээр хоёр, гурван хувилбаруудыг судалж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох. Ер нь энэ хяналтын тогтолцоог хараат бус үр нөлөөтэй болгохыг л иргэд дэмжсэн гэж ойлгож байгаа.

Тэгэхээр сая яригдсан хувилбарууд аль аль нь яригдаж байгаа. Бодлогын түвшиндээ шийдэгдээд явах байх гэж бодож байна.

Тэгээд ер нь би түрүүн үг хэлж байхдаа бас нэг дурдсан зүйл юу вэ гэхээр иргэд. Энэ Зөвлөлдөх санал асуулга бол тохиолдлоор сонгогдсон иргэдэд хоёр талын мэдээлэл өгөөд тэгээд иргэд дэмжиж байна уу, үгүй юу, юу гэж бодож байна гэдгийг гаргаж ирж байгаа юм. Энэ бол зөвхөн эхний процессын хэсэг. Үүний араас тухайн иргэдийн дэмжсэн зүйлүүдийг нарийвчилж судлах, хууль тогтоомжид

тусгах, ахиад иргэдээс санал авах энэ процессууд үргэлжлээд явна гэж ойлгож байгаа.

Түрүүн бас Ц.Мөнхцэцэг гишүүний хэлсэн зүйл дээр нэг санаа нэмэх гэсэн юм. Тэр нь юу вэ гэхээр жендэртэй холбоотой асуулт асуугдсан. 503 дугаар асуултаар нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш эрх хангагдаж байна уу, үгүй юу гэдэг ийм асуулт асуугдаад энэ дээр энэ тэгш байдлыг хууль тогтоомжид тусгаж гүйцээж хэрэгжүүлэх ёстой гэсэн ийм зөвлөмжийг Зөвлөлдөх зөвлөл гаргасан.

60 асуултаас шүүгдээд 22 асуулт болсны гол шалтгаан юу вэ гэхээр энэ Зөвлөлдөх санал асуулгын онол нь цаанаа юу юм гэхээр иргэдийн ойлгож хүлээж авах боломжтой тэр хүрээнд асуулт асууж, мэдээлэл өгч байж тэр жинхэнэ хүсэл зориг нь гарна гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр хэт олон бүх чухал асуултыг асуучих юм бол хоёрхон өдрийн дотор иргэдэд амаар, бичгээр тайлбарлаж ойлгуулах боломжгүй учраас Зөвлөлдөх зөвлөл бол Төрийн байгуулалтын байнгын хорооны өгсөн чиглэлийн дагуу эрэмбэлээд энэ удаа асууя гэсэн 22 асуултаа гаргасан. Тийм.

Тэгэхээр бид бас харьцангуй боломжоороо нэлээн олон чухал асуултуудыг асуугаад иргэдийнхээ санаа бодлыг сонсчихсон гэж ойлгож байгаа. Тэгээд үүний дараа цаашаа зүйлүүд хийгдэнэ байх.

Гадаад улсын туршлага ч гэсэн бас тийм юм билээ. Яагаад гэхээр иргэдэд хэт их өргөн хүрээний асуулт тавиад, хэдий их мэдээлэл өгөх юм бол бодитой биш болдог.

Жишээлбэл, Австралид төрийн тэргүүн нь хаан байгаа энэ байдлыг халж бүгд найрамдах улс руу шилжих үү, үгүй юу гэсэн ганцхан л асуулт асууж байгаа байхгүй юу. Үүнийхээ хүрээнд хэрвээ бүгд найрамдах засаглал руу шилжих юм бол төрийн тэргүүнээ парламентаасаа шууд бусаар сонгох уу, иргэдээсээ шууд сонгох уу гээд тойруулсан асуултуудыг асуугаад л Зөвлөлдөх санал асуулга хийж байсан жишээтэй.

Тэгэхээр манайд ч гэсэн яг ийм байдлаар бид аль болох хүрээгээ хумьж бодитой иргэдийн оролцоог хангах гэсэн Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1-д заасан тэр зарчмыг хэрэгжүүлэх үүднээс асуултуудаа шигшсэн байгаа гэдэг ийм нэмэлт тайлбарыг хэлье. Баярлалаа.

Н.Энхболд: Болгосон уу? Дарга. Хариулт болох уу?

Би ганцхан асуулт асуучихъя. Одоо бид Зөвлөлдөх зөвлөлөөс гаргасан санал, дүгнэлт, зөвлөмжийн дагуу зарим хууль, тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулах ийм ажлуудыг хийнэ. Өөрөөр хэлбэл та нарын энэ гаргаж ирсэн зүйлүүд дараа дараагийн Их Хурлын шийдвэрүүдийн үндсэндээ үзэл баримтлал, үндэслэл, шийдвэр, суурь нь болно гэсэн үг.

Яг энэ талаас нь хараад үзвэл энэ Зөвлөлдөх зөвлөлийнхний хийсэн ажил зөв байсан, үндэслэлтэй байсан гэдэг энэ ойлголтыг нийгэмд өгөх нь онцгой чухал байгаа юм.

Тэгэхээр миний асуулт юу вэ гэхээр энэ эцсийн санал, дүгнэлт, зөвлөмжөө гаргахдаа манай Зөвлөлдөх зөвлөлийн гишүүд бүгдээрээ яг энэ гарын

үсэг зурсан юман дээрээ санал нэг, нэгдмэл байр суурьтай байсан уу гэдэг асуулт л байгаа юм. Яагаад үүнийг асууж байна гэдгийг би түрүүн хэлсэн. Тийм ээ. Энэ бол өөрөө дараагийн хууль тогтоомжийг ярих, боловсруулах, батлах сүүлийн нэг том үндсэн суурь болох учраас ийм итгэл үнэмшил олон нийтэд хэрэгтэй.

Тэгэхээр энэ дээр товчхон хариулт өгчхөөрэй.

Түрүүн Ц.Мөнхцэцэг гишүүн бас асуулт дундаа ярьж байсан.

Ер нь тухайлбал парламентын чадавхыг бэхжүүлэхтэй холбоотой асуудал дээр яг ямар тайлбартайгаар энэ талаараа хүмүүсийн саналыг авч дүнг нь гаргасан бэ гэж. Бид зөвхөн энэ асуудал биш, энэнээс бусад бүх асуудлуудаар, ялангуяа сүүлийн шатанд орсон асуудлуудаар яг тухайн асуудлыг тойрсон давуу, сул талуудыг нь бүгдийг нь нэлээн сайн дэлгэрэнгүй хоёр өдрийн турш тэр хүмүүстэйгээ ярилцаж байгаад ингээд өгсөн.

Миний хувийн бодол бол хүмүүс аль болох аливаа асуудлыг дагасан давуу, сул талуудын давуу талуудыг нь харж энэ нь хэрэгтэй юм байна, энэ нь зөв юм байна гэж бодож саналаа өгсөн гэж ингэж бодож байгаа. Аль ч талаас нь бодоод үзсэн.

Тэгэхээр тэр тайлбар дотор тухайлбал, холимог тогтолцооны тухай, гишүүдийн тооны тухай. Энэ дээр өгсөн тайлбаруудын давуу тал нь энэ юм байна гэж үзээд саналаа өгсөн гэж бодохоор тухайлбал тэр асуудлууд би олон нийтийн зүгээс тодорхой хэмжээний дэмжлэгтэй байна гэж ингэж ойлгож байгаа. Тэгээд давуу тал талаас нь

тайлбарласныг нь ойлгож саналаа ингэж өгсөн гэж бодож байгаа.

Яагаад үүнийг хэлж байна гэхээр цаашдаа энэ чиглэлээр бас тодорхой ажлууд хийгдэж зарим хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт орох асуудал гаргахыг үгүйсгэхгүй. Энэ үед энэ асуултад өгсөн хариултауд бидний цаашдын үйл ажиллагааны зарчим, чиглэлийг тодорхойлсон ийм дэвсгэр суурь болно гэдэг үүднээс ингэж байгаа юм.

Тэгээд би түрүүчийнхээ асуултад ганцхан. Энэ дээр ямар нэгэн дотроо маргалдсан, зөрчилдсөн юм байхгүй биз дээ гэж асууж байна. Санал нэгтэй байсан уу гэж. Би итгэлтэй байгаа. Яагаад гэвэл даргын зөвлөл дээр даргад танилцуулахад бид яг ийм байр суурийг чинь сонирхсон.

Тэгэхдээ бид өнөөдөр энэ нээлттэй ингээд Байнгын хорооны хурал дээр хэлэлцэж байгаа учраас энэ талын мэдээлэл бас олон нийтэд ч гэсэн хэрэгтэй гэж бодож байна.

Г.Чулуунбаатар даргыг хариулахыг хүсье. 3 номерын микрофон.

Г.Чулуунбаатар: Санал асуулгын асуултыг боловсруулах явцад ч тэр, зөвлөмжийг боловсруулж, эцэслэн батлах явцад ч тэр мэдээж хэлэлцүүлэг явсан.

Эцэслэн тогтсон зүйл дээр зөвлөлийн гишүүд нэгдмэл, санал нэгтэй байсан. Ялангуяа зөвлөмж дээр бүгдээрээ санал нэгдэж, гарын үсэг зурсан. Өөр байр суурь илэрхийлсэн хүн байхгүй байгаа.

Зүгээр хоёр дахь асуудалтай холбогдуулаад ерөнхийдөө би нэг тайлбар хэлчихье гэж бодсон юм.

Ер нь Зөвлөлдөх зөвлөл хуулиараа ч тэр, бүрэлдэхүүн чадавхаараа ч гэсэн тэр Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулаад, асуултыг боловсруулаад, асуусан асуулт, гарсан тоондоо захирагдаж зөвлөмжөө гаргана. Түүнээс цааш алхам хийх эрх зүйн боломж ч, тийм чадавх, чадамж ч байхгүй юм.

Тийм учраас зөвлөмжийн төгсгөл дээр хоёр санааг хэлсэн байгаа.

Нэгдүгээрт, Зөвлөлдөх санал асуулгын хоёр дахь шатны зөвлөлдөх уулзалт дээр 250, 260-аад цагийн бичлэг хийгдсэн байгаа. Бичил бүлгүүдэд болон нэгдсэн хуралдаан дээр. Түүн дээр Та бүхний сонирхоод байгаа тэр гишүүдийн тухайн асуултын давуу, сул талын алиныг нь голлож ойлгоод юу гэж бодоод хариулж вэ гэдэг мэдээлэл гарчихсан байгаа юм.

Тэгэхээр түүн дээр мэргэжлийн баг гаргаж, контент анализ хийлгээд, тэгээд хуулийнхаа төсөл юм руу явбал зүгээрээ гэж бодож байна. Гэсэн зөвлөмжийг бичсэн байгаа.

Хоёрдугаарт, Үндэсний статистикийн хороон дээр хоёр шатны санал асуулгын явцаар бий болсон мэдээлэл өөрөө маш өргөн агуулгатай, багтаамжтай мэдээлэл бий. Түүнийг асуултад орсон 22 асуултаас гадна 30 гаруй асуулт байгаа.

Тэр асуултуудыг хооронд нь харьцуулаад хэн гэдэг хүн, ямар мэдлэг, боловсрол, орон нутгийн харьяалал, хүйс, мэргэжил гэх мэтээр нь харьцуулаад энэ асуултад энэ бүлэг яаж хариулж вэ гэдгийг бодоод гаргачих тийм бололцоо бүрэн байгаа юм.

Тэгэхээр энэ хоёр дээр л цаашдаа мэргэжлийн баг ажиллаад яг ямар хуульд ямар концепцоор ямар өөрчлөлт тусгах ёстой вэ гэдгийг тодруулах шаардлагатай юм. Зөвлөлдөх зөвлөлийн хувьд бол ийм боломж байхгүй юм гэдгийг л хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. Гишүүд асуулт тавьж, хариулт авч дууслаа.

Одоо танилцуулгатай холбогдуулаад үг хэлэх хүн байна уу? Байхгүй байна.

Саналаа тасалчихъя. Түрүүн бид ярьсан нэг тогтоол гаргах нь зүйтэй байх гэж чиглэл өгсөн. Сая Их Хурлын даргаас бас санал гарч байна.

Байнгын хорооных байх уу? Бид мэдээж Их Хурлаас тогтоол байх нь дээр үү гэж бодож тал талаас нь ярьж байгаад энэ дээрээ нэг шийдлээ олоод. Хэрэв Байнгын хорооноосоо гаргая гэвэл өнөөдөр тогтоолоо баталчихъя. Чуулган дээрээ ярья гэвэл ярьж болно. Байнгын хорооноосоо оруулаад.

Ер нь Их Хурлын Байнгын хорооны тогтоол бол Их Хурлын шийдвэрийн бас нэг хэлбэр л гэж ойлгож байна. Тэгээд энэ дээрээ асуудлаа шийдээд хэдүүлээ Байнгын хороогоороо гаргаад тогтоолоо батлаад Засгийн газартаа чиглэл өгөөд явчих нь дээр болов уу гэсэн зүгээр миний хувийн байр суурь.

Энэ дээр гишүүд саналаа хэлэх үү? Дэмжиж байгаа нь чимээгүй байвал тэгээд саналаа хураачихъя.

Тэгвэл Байнгын хорооныхоо тогтоолыг гаргая гэдэг дээрээ

ойлголцчихъё. Тэгэх үү. Эсэргүүцсэн хүн алга байна.

Би тэгвэл Байнгын хорооны тогтоолын төсөл Та бүхэнд нэг танилцуулчихъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.“Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын нэг бас хоёр дахь шатны санал асуулгын дүнгээр оролцогчдын олонхын саналаар дэмжигдсэн засаглалыг бэхжүүлэх, эдийн засаг, баялгийн сан, төвлөрлийг сааруулах болон нийгмийн тулгамдсан асуудлын талаар Зөвлөлдөх зөвлөлийн зөвлөмжийг судлан, санал, дүгнэлт боловсруулах, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжийн төслүүдийг боловсруулан өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай

гэсэн ийм Байнгын хорооны тогтоолын төсөл байна.

Тогтоолын төслөөс асуух гишүүн байна уу? Саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Би сая төслийг нь уншсан. Энэ тогтоолын төсөлтэй танилцаад Байнгын хорооны тогтоол болгож баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 54.5 хувиар дэмжлээ.

Байнгын хорооны тогтоол батлагдлаа. Баярлалаа. Нэгдүгээр асуудлаа хэлэлцэж дууслаа.

Ажлын хэсэгтээ баярлалаа. Оролцсон бүх хүмүүст. Зөвлөлдөх зөвлөл, ажлын хэсгийнхэндээ.

Цаашид шаардлага гараад хууль боловсруулах асуудал үргэлжлээд явахад бас манай ажлын хэсэгт оролцож байсан хүмүүс, Зөвлөлдөх зөвлөлийн гишүүд маань идэвхтэй, санаачилгатай оролцоно гэж найдаж байна. Тийм боломжийг нь бас Улсын Их Хурлын зүгээс бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаагаар бас хэлье.

Баярлалаа Та бүхэнд.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хоёр дахь асуудалдаа орёе. Энэ хаврын чуулганы хугацаанд 3 дугаар сард Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар бид батлах ёстой. Гишүүдэд тараасан байгаа.

Өнөөдрийн байдлаар хоёр асуудал, гурван асуудал байна.

Нэгдүгээрт, хуулийн дагуу Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, Засгийн газрын 2020-2024 оны

үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэх ёстой.

Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай Байнгын хорооны тогтоол бид гаргах ёстой. Эхний ээлжинд тов даргалагчаа тогтоох ёстой.

Хоёрдугаарт, Төрийн албаны зөвлөлд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай бас Байнгын хорооны тогтоол гаргах ёстой.

Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүдээс 2-ыг нөхөж сонгох ийм шаардлага байгаа. Засгийн газраас нэр дэвшүүлж хэлэлцүүлэх ёстой. Нэрс нь ирчихсэн байж байгаа.

Төрийн албаны зөвлөлд бас нэг байгаа. Тийм ээ. 2 хүнийх байгаа. Засгийн газраас нэр дэвшүүлсэн санал ирчихсэн байж байгаа. Бид үүнийгээ бас хэлэлцэх ёстой.

Улсын Их Хурлаас нэг хүнийг бас нөхөж дэвшүүлэх ёстой. Тэр нь одоогоор ирээгүй байна.

Тэгээд энэ асуудлуудаа хэрэв бид хэлэлцье гээд одоо шийднэ гэвэл 21-ний Байнгын хорооны хурлаар. Дараагийн

долоо хоногт хэлэлцээд тэгээд түүн дээрээ тогтоолуудаа гаргана.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувьд гэвэл бид Төрийн байгуулалт, Эдийн засгийн байнгын хороо нь хамтарч 21-ний өдөр хуралдаад тэгээд хуулийн хугацаанд багтаагаад дараа долоо хоногт буюу 31-ний Баасан гарагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар гүйцэтгэлийн тайланг хүлээж авах, батлах ийм ажил хийгдэх ёстой. Ийм цаглаварыг Та бүхэнд танилцуулж байна.

Асуулт, саналтай хүн байна уу? Байхгүй юу. /алх цохив/

Тэгвэл Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглаварыг тараасан төслийн дагуу баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн оролцож, 63.6 хувиар цаглавар батлах тогтоол батлагдлаа.

Гишүүддээ баярлалаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дуусаж байна. Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа.

21-ний өдөр Байнгын хорооны хуралдаантай. Цагийг зарлана. Ажлын албанаас. Баярлалаа. Өнөөдрийн хуралдаан дууслаа. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 07 минут үргэлжилж, 13 цаг 44 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД